



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №19

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдлын мэдээлэл:

2022 оны 10-р сарын 25 наас 11-р сарын 30 ны хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Хоёр. Шувууны томуугийн хүний өвчлөлийн олон улсын мэдээлэл:

2022 оны 10-р сарын 25 наас 11-р сарын 30 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H3N8, H7N9, H9N2, H6N1, H10N8, H7N4, H5N6, H5N8, H10N3 вирусын хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

А хүрээний **H5N1** вирусын хэв шинжээр Испани улсад хүний өвчлөлийн 2 тохиолдол, БНХАУ-д 1 тохиолдол бүртгэгдсэн. Эхний 2 тохиолдол болох Испани улсын Гвадалахара хотын 19, 27 настай эрэгтэй хүмүүс нь шувууны томуу (А/H5N1) ханиадаар өвдсөн тухай 2022 оны 11 сарын 03 нд мэдээлсэн. Ханиадны ямар нэг шинж тэмдэг илрээгүй.

БНХАУ-н Гуанси мужийн 38 настай эмэгтэйд ханиадны шинж тэмдэг 9-р сарын 22 ноос илэрч эхэлсэн ба 25 ны өдрөөс эмчилгээг эхэлсэн боловч 10-р сарын 08 нд нас барсан байна.

Гурав. 2022 оны 10-р сарын 25 наас 11-р сарын 30 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн шувууны мэдээлэл:

2022 оны 10-р сарын 25 наас 11-р сарын 30 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Австри, Бельги, Колумби, Дани, Эквадор, Франц, Герман, ХонгКонг, Ирланд, Итали, Израйл Мексик, Молдав, Голланд, Перу, Польш, Португал, Өмнөд Солонгос, Румин, ОХУ, Серб, Словени, Өмнөд Африк, Испани, Швед, Швейцар, Норвеги, Тайвань, Их Британи, АНУ, зэрэг 31 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 343 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 1 ээс харна уу). Хун, галуу, нугас зэрэг нүүдлийн усны 28 зүйлийн шувуу, хөхтөн амьтны 1 зүйлд өвчлөл бүртгэгдсэн байна.

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусын хэв шинжээр тархалт

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	Австри	Тэжээвэр шувууд	1
H5N1	Бельги	<i>Cairina moschata</i> , Дэглий, цахлай, сар, Common pheasant, шонхор, хун гм	24
H5N1	Колумби	Тэжээвэр шувууд	9
H5N1	Дани	Цацаг хяруул, Common pheasant, нугас	10
	Эквадор	Тахиа	1
H5N1	Франц	Тогоруу, <i>Streptopelia decaocto</i> , <i>Cairina moschata</i> , Дэглий, цахлай, сар, Common pheasant, шонхор, хун гм	28
H5N1	Герман	Зэрлэг болон тэжээвэр нугас, цацагт хяруул, бор шувуу, цахлай, хун,	28
H5N1	ХонгКонг	Тэжээвэр шувууд	2
H5N1	Унгар	Тэжээвэр шувууд	28
H5N1	Ирланд	Гургуул, Сар шувуу, Хун	4
H5N1	Израйл	Цацагт хяруул, Гургуул, Сар шувуу, Хун	2

H5N1	Итали	Нугас, Хун, Гургуул, Сар шувуу, Хун	16
H5N1	Япон	Тогоруу, Галуу, Шонхор, Бусад тэжээвэр шувууд	29
H5N1	Мексик	Нугас, тэжээвэр	4
H5N1	Молдав	Тэжээвэр шувууд	1
H5N1	Голланд	Тахиа	6
H5N1	Перу	Борцгор хотон	1
H5N1	Польш	Тэжээвэр шувууд	1
H5N1	Португал	Хөх дэглий	1
H5N1	Өмнөд Солонгос	Тэжээвэр шувууд	18
H5N1	Румин	Гунгар хун	1
H5N1	ОХУ	Тэжээвэр шувууд	2
H5N1	Серби	Гунгар хун	2
H5N1	Словени	Гунгар хун	2
H5N2	Өмнөд Африк	Тэжээвэр шувууд	1
H5N1	Испани	<i>Morus bassanus</i> , цахлай, галуу	4
H5N1	Швед	Эгэл шонхор, Хун	3
H5N1	Швейцар	Хөх дэглий	1
H5N1	Тайвань	Тэжээвэр болон зэрлэг нугас	3
H5N1	Их Британи	Тэжээвэр болон зэрлэг нугас, цацагт хяруул, галуу, цахлай	73
H5N1	АНУ	<i>Mephitis mephitis</i> , Тэжээвэр шувууд	34
H5N1	Вьетнам	Тэжээвэр шувууд	2

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

(Зураг 1) 2022 оны 10-р сарын 25 наас 11-р сарын 30 ны хооронд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусн тохиолдлын тархалт

